



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/18/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsuren@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Төлбөрийн акт.....	12
4.3 Албан шаардлага.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас: 705924319, 705923208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

**ИХ ГАЗРЫН ЧУЛУУ БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Р.БАТТҮВШИН ТАНАА**

2022.02.15 № 04
Төрийн _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

0012020673

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,197,125.11	62,033,624.00
33	АВЛАГА	27,225.11	00.00
335	Бусад авлага	27,225.11	00.00
3351	Байгууллагаас авах авлага	27,225.11	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,169,900.00	62,033,624.00
351	Түүхий эд материал	60,002,300.00	59,976,100.00
35110	Тусгай зориулалттай материал	60,002,300.00	59,976,100.00
354	Хангамжийн материал	1,167,600.00	2,057,524.00
35420	Аж ахуйн материал	144,000.00	307,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	95,100.00	111,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	445,500.00
35470	Бусад хангамжийн материал	928,500.00	1,194,024.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	308,163,937.85	358,601,028.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	308,163,937.85	358,601,028.30
392	Биет хөрөнгө	300,017,937.85	350,644,228.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	204,939,880.00	229,922,225.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,248,072.88	-10,413,454.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,439,907.21	130,079,907.21
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,172,443.06	-31,347,867.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53,689,860.81	55,451,148.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,675,140.96	-35,830,098.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,102,931.39	11,102,931.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,058,984.66	-8,797,229.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,000,000.00	11,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,023,333.27
393	Биет бус хөрөнгө	8,146,000.00	7,956,799.96
39301	Програм хангамж	946,000.00	946,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-189,200.04
39303	Бусад биет бус хөрөнгө	7,200,000.00	7,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	369,361,062.96	420,634,652.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	180,400.00	180,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	180,400.00	180,400.00
413	Өглөг	180,400.00	180,400.00
4136	Бусад өглөг	180,400.00	180,400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	180,400.00	180,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	369,180,662.96	420,454,252.30
51	Засгийн газрын хувь оролцоо	369,180,662.96	420,454,252.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,200,000.00	7,200,000.00
51101	Өмч: - төрийн	7,200,000.00	7,200,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	361,980,662.96	413,254,252.30
51210	Өмнөх үеийн үр дүн	361,980,662.96	361,980,662.96
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	51,273,589.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	369,361,062.96	420,634,652.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	280,391,007.21	259,576,445.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,636,007.21	72,364,545.00
120	Нийтлэг татварын бус орлого	76,636,007.21	72,364,545.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,636,007.21	72,364,545.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	388,100.00	365,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,247,907.21	71,999,345.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,755,000.00	187,211,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	191,062,000.00	184,711,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	191,062,000.00	184,711,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,693,000.00	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,700,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	993,000.00	2,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	211,867,237.35	208,233,559.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	211,867,237.35	208,233,559.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	194,475,684.14	206,362,266.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,386,268.68	107,201,828.00
210101	Үндсэн цалин	76,869,266.19	84,948,962.00
210102	Нэмэгдэл	21,086,702.49	18,822,566.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,430,300.00	3,430,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,792,974.00	14,076,114.11
210201	Тэтгэврийн даатгал	8,761,297.00	9,985,205.38
210202	Тэтгэмжийн даатгал	972,371.00	1,002,337.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	843,435.00	865,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	201,075.00	201,382.36
210205	Эрүүл мэндийн даатгал	2,014,796.00	2,021,488.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,754,824.00	8,195,460.00
210301	Гэрэл, цахилгаан	758,704.00	635,020.00
210302	Түлш, халаалт	7,470,100.00	7,089,100.00
210303	Цэвэр, бохир ус	526,020.00	471,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,995,493.00	8,506,911.00
210401	Бичиг хэрэг	478,620.00	584,050.00
210402	Тээвэр, шатахуун	8,287,500.00	6,432,321.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,293,196.00	974,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	936,177.00	515,680.00
2105	Нормативт зардал	9,600.00	228,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,600.00	228,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,000.00	95,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,000.00	95,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,510,800.00	1,379,000.00
210702	Дотоод албан томилолт	1,510,800.00	1,379,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,479,642.20	41,158,819.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,693,698.20	40,519,495.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,400.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,544.00	170,424.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,530,082.26	25,521,034.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	103,200.00	80,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,426,882.26	25,441,034.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,391,553.21	1,871,293.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	726,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	726,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,665,553.21	1,871,293.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,665,553.21	1,871,293.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	68,523,769.86	51,342,885.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	471,572.00	69,296.37
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	471,572.00	69,296.37

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-471,572.00	-69,296.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	68,052,197.86	51,273,589.34

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,200,000.00	293,928,465.10	301,128,465.10
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,200,000.00	293,928,465.10	301,128,465.10
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	68,052,197.86	68,052,197.86
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,200,000.00	361,980,662.96	369,180,662.96
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,200,000.00	361,980,662.96	369,180,662.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,200,000.00	361,980,662.96	369,180,662.96
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	51,273,589.34	51,273,589.34
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,200,000.00	413,254,252.30	420,454,252.30

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	204,143,100.00	187,577,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	388,100.00	365,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	388,100.00	365,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	388,100.00	365,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	388,100.00	365,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,755,000.00	187,211,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	191,062,000.00	184,711,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	191,062,000.00	184,711,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,693,000.00	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,700,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	993,000.00	2,500,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	200,863,100.00	183,663,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	200,863,100.00	183,663,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	183,471,546.79	181,791,807.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,413,493.79	107,175,603.00
210101	Үндсэн цалин	76,896,491.30	84,922,737.00
210102	Нэмэгдэл	21,086,702.49	18,822,566.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,430,300.00	3,430,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,792,974.00	14,076,114.00
210201	Тэтгэврийн даатгал	8,761,297.00	9,985,205.27
210202	Тэтгэмжийн даатгал	972,371.00	1,002,337.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	843,435.00	865,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	201,075.00	201,382.36
210205	Эрүүл мэндийн даатгал	2,014,796.00	2,021,488.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,754,824.00	8,640,960.00

210301	Гэрэл, цахилгаан	758,704.00	635,020.00
210302	Түлш, халаалт	7,470,100.00	7,534,600.00
210303	Цэвэр, бохир ус	526,020.00	471,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,533,593.00	8,959,911.00
210401	Бичиг хэрэг	443,220.00	584,050.00
210402	Тээвэр, шатахуун	8,287,500.00	6,432,321.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,733,196.00	974,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,069,677.00	968,680.00
2105	Нормативт зардал	237,600.00	237,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	237,600.00	237,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	111,100.00	111,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	111,100.00	111,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,510,800.00	1,379,000.00
210702	Дотоод албан томилолт	1,510,800.00	1,379,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,013,962.00	41,131,619.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,228,018.00	40,492,295.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,400.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,544.00	170,424.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,200.00	80,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	103,200.00	80,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,391,553.21	1,871,293.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	726,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	726,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,665,553.21	1,871,293.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,665,553.21	1,871,293.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,280,000.00</u>	<u>3,914,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>3,280,000.00</u>	<u>3,914,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>3,280,000.00</u>	<u>3,914,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>3,280,000.00</u>	<u>3,914,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,280,000.00	3,914,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3,280,000.00</u>	<u>-3,914,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	185,061,900.00	185,077,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	185,061,900.00	185,077,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	185,061,900.00	183,205,807.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	108,212,500.00	107,175,603.00

210101	Үндсэн цалин	85,959,300.00	84,922,737.00
210102	Нэмэгдэл	18,822,900.00	18,822,566.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,430,300.00	3,430,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,608,700.00	14,076,114.00
210201	Тэтгэврийн даатгал	10,280,200.00	9,985,205.27
210202	Тэтгэмжийн даатгал	1,082,100.00	1,002,337.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	865,700.00	865,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	216,400.00	201,382.36
210205	Эрүүл мэндийн даатгал	2,164,300.00	2,021,488.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,656,700.00	8,640,960.00
210301	Гэрэл, цахилгаан	635,020.00	635,020.00
210302	Түлш, халаалт	7,541,180.00	7,534,600.00
210303	Цэвэр, бохир ус	480,500.00	471,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,960,000.00	8,959,911.00
210401	Бичиг хэрэг	584,050.00	584,050.00
210402	Тээвэр, шатахуун	6,432,400.00	6,432,321.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	974,870.00	974,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	968,680.00	968,680.00
2105	Нормативт зардал	237,600.00	237,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	237,600.00	237,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	111,100.00	111,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	111,100.00	111,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,427,800.00	1,379,000.00
210702	Дотоод албан томилолт	1,427,800.00	1,379,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,764,900.00	42,545,619.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,125,500.00	41,906,295.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,500.00	170,424.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82600.00	80000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,600.00	80,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	184,711,900.00	184,711,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	184,711,900.00	184,711,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	184,711,900.00	184,711,900.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	13.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	06.00	06.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,500,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,500,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын захиргаа нь эрхэм зорилгоо “Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах замаар Их газрын чулууны БЦГ-н биологийн төрөл зүйл, экологийн тэнцвэрт байдал тэдгээрийн унаган төрхийг хадгалан хамгаалж хойч үедээ өвлүүлэн үлдээхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Байгаль, орчин аялал жуулчлалын яамны Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 3 дугаар улирлын

санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 3 дугаар улирлын нийт хөрөнгийн 360,885.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,608.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэн, төлөвлөлтийн шатанд хэвээр үлдээсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,273.6 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан хөрөнгийн 98.3 хувь нь эргэлтийн бус хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
БАЙГУУЛЛАГААС АВАХ АВЛАГА	27.23	-	(27.23)
БАРАА МАТЕРИАЛ	61,169.90	62,033.62	863.72
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	308,163.94	358,601.03	50,437.09
НИЙТ ӨР ТӨЛБӨР	180.40	180.40	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	180.40	180.40	-
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	369,180.66	420,454.25	51,273.59
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	369,361.06	420,634.65	51,273.59

Бараа материал дансны үлдэгдэл 62,033.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 863.7 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын өсөлт байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 3,914.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, дээд шатны байгууллагаас 24,982.3 мянган төгрөгийн барилгын дээврийн засвар, 42,640.0 мянган төгрөгийн шинэ авто машин, 2,377.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна. Мөн 2,029.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг актлан, данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 420,454.3 мянган төгрөг болж 51,273.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 280,459.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 280,459.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс байгаль хамгаалах сангийн зардлыг өмнөх онтой харьцуулан 92,007.2 мянган төгрөгийг бууруулж нийт санхүүжилтийг 188,452.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 188,452.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 12 сард ковидтой холбоотой 3,374.9 мянган төгрөгийн тодотгол хийн бууруулж, 185,077.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 184,077.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 98.9 хувийг зарцуулж, 1,871.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 182,206.6 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын гүйцэтгэл буюу батлагдсан орон тооноос дутуу үйл ажиллагаагаа явуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Их газрын чулууны булгийн эхийг хаших төслийн 2,500.0 мянган төгрөгийг тухайн төсвийн захирагчид хуваарилан орлогыг бүрдүүлжээ.

Булгийн эхийг хаших төслийн хүрээнд эхийг хашин, бусад хөрөнгийн дансанд худгийг бүртгэлд авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын авто тээврийн хэрэгсэл 42,640.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Уг хөрөнгийн худалдан авах ажиллагааг дээд шатны байгууллага зохион байгуулан худалдан авч шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын захиргаа нь 2021 онд нийт 176,493.4 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулснаас 160,461.4 мянган төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж, хэрэгжилт 92.7 хувьтай байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 17,685.8 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 26,396.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 26,005.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 211.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 180.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн зардлаас 25.2 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зарцуулан тайлагнасан;
2. Санхүүгийн тайланд түлш халаалтын зардлыг 727,600 төгрөг, албан томилолтын зардлыг 36,000 төгрөгөөр анхан шатны баримтнаас зөрүүтэй тайлагнасныг;
3. Албан томилолттой албан хаагчдад 234.0 мянган төгрөгийн хоолны мөнгө давхардуулан олгосон;
4. Барилгын дээврийн засварын 24,982.3 мянган төгрөгийг сайжруулалтаар бүртгээгүй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохдоо 1 ажилтанд тооцооллын алдаанаас 211,421.00 төгрөгийг хэтрүүлэн олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Аудитаар насжилт өндөртэй 180.4 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Шийдвэрлэсэн нь: Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын захиргаа	6	26,396.9	4	26,005.1	1	211.4	1	180.4		